



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 02/53

Баян-Өндөр сум

Хугацаа сунгах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 14/05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд, шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулах, зөвшөөрөл олгох, хугацаа сунгах журам”-ын 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлт ирүүлсэн “Бал Сажа Лэгшад Норовлин” хийд, “Жалданжанчүвлин” хийд, “Төгсбуянт” хийд, “Очир сүм” хийд, “Хутагт ламын Ганданшаддүвлин” хийд, “Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Эрдэнэт цуглаан”, “Дэнж хайрын илгээлт” сүм, “Библи судлаач” шашны байгууллага, “Эрдэнэт Дэлхийн гэрэл сүм”, “Эрдэнэт бурхны” сүм, “Монголын илгээлтийн төв”, “Амьд үг-Эрдэнэт” сүм, “Есүсийн чуулган” сүм, “7 дахь өдрийн адвентист” сүм, “Христийн Дааман хаалга” сүм, “Алдарт Христийн Эрдэнэт чуулган”, “Каусар Эрдэнэт Мешит” шашны байгууллагуудын зөвшөөрлийн хугацааг 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн тус тус хоёр жилийн хугацаатай сунгасугай.

2. Төр сүм хийдийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журамд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж, холбогдох тайлан, мэдээг хугацаанд нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ирүүлж байхыг дээрх сүм, хийдүүдэд даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХБАТ



6125010148